



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Мандах сумын Эрүүл мэндийн төвийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/46/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.dornogovi@audit.gov.mn Сайншанд сум 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Т.Оюунтуяа Утас: 99048991 Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn
--	---



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.08.25 № 16/169

танай _____-ны № _____-т

МАНДАХ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Э.ЧУЛУУНЦЭЦЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мандах сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандах сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

This PC: D/2022 onii ajil/A4 тоот

010020078

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	60.8	222.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	426.3	434.8
	Нийт хөрөнгийн дүн	487.1	657.4
	Нийт өр төлбөрийн дүн	0	38.2
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	487.1	619.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	487.1	657.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	360.7	784.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	367.6	621.3
	Үйл ажиллагааны үр дүн	(6.9)	163.2
	Үйл ажиллагааны бус үр дүн	0	(31.1)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(6.9)	132.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	521.3
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(34.2)
	Тайлант оны үр дүн	0	132.1
	Эцсийн үлдэгдэл	487.1	619.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	347.3	415.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	345.8	406.6
	Үйл ажиллагааны ЦМГ	1.4	8.6
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(1.4)	(5.1)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0	0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0	3.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	3.5
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	357.3	356.8
	Урсгал зардал	357.3	356.8
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	357.3	360.2
	Улсын төсвөөс санхүүжих	326.9	326.9
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	14.4	14.4
	НД-ын сангийн төсвөөс санхүүжих	16.0	18.9

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Мандах сумын Эрүүл мэндийн төв нь үйл ажиллагааны чиглэлээ “Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлагад төлөвшүүлж, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, халдварт өвчнийг бууруулах, эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлнэ” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудит болон аудитор байхгүй.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дэлгэрэнгүй бүртгэл болон бусад баримт мэдээллийг шалгахад тус байгууллага нь тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 362.1 сая төгрөгийн 17 орлогын гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 37.3 сая төгрөгийн 4 худалдан авалтын гүйлгээг байршуулахаар байна.

Дээрх мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэлтэй тулгаж, шалгахад нийт 10 мэдээллийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 18.6 сая төгрөгийн орлогын 3 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 37.3 сая төгрөгийн худалдан авалтын 4 гүйлгээг мэдээлээгүй байна.

3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 68.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5.3 сая төгрөгийн алдааг залруулж, 1 албан шаардлага хүргүүлж, 7.6 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах 2 залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Элэгдлийн тооцооллыг давтан гүйцэтгэхэд 1.7 сая төгрөгийн элэгдлийн зардлыг илүү тооцсоныг;
2. Хасагдсан хөрөнгийн элэгдлийг данснаас хасахдаа 3.5 сая төгрөгөөр дутуу хасаж, алдаатай бүртгэснийг залруулав.

Албан шаардлага

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 10 мэдээллийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 18.6 сая төгрөгийн орлогын 3 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 37.2 мянган төгрөгийн худалдан авалтын 4 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-т Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6 дугаар зүйлийн 6.4.5-т “...орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр,...” тус тус мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний данстай холбоотой асуудал:

1.1. *Илрүүлэлт:* 2021 онд аж ахуйн нэгж байгууллагуудаас и-баримтгүй 7.6 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 4.1.14-т “төлбөрийн баримт” гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг”, 17.3.2-т “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”; 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

1.2. *Өгсөн зөвлөмж:* Худалдан авалтыг тооцоо хийгдсэн тухай бүрд нь цаасан болон цахим и-баримтыг үндэслэн санхүүгийн тайланд тусгаж ажиллах

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	+	+			+			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	4	12.9	2	5.3			1	-	1	7.6
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	4	12.9	2	5.3			1	-	1	7.6